**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 11 өдөр Дугаар A/525 Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 20 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 650,000.0 (зургаан зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн хүүхдийн 20 дугаар цэцэрлэг (Д.Мөнхзаяа)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс (О.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

[illegible]

I. Oeyuaa

1425031303

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/515 дугаар тушаалын хавсралт

# Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн хүүхдийн 20 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт дүн | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг /2025.10.31/ | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сандал | Хятад | 2023 | ш | 5 | 130,000.00 | 650,000.00 | 270,834.00 | 379,166.00 | БЗДүүргийн Боловсролын хэлтэс |
| Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн | | | | | 5 | | 650,000.00 | 270,834.00 | 379,166.00 | |